

ТЕЛЕВИЗИЙН ХӨТЛӨГЧИЙН ДҮР ТӨРХИЙН ТУХАЙ ӨГҮҮЛЭХ НЬ

Шилингуа*

* Өвөр Монголын Их Сургуулийн багш

Түлхүүр үг: хөтлөгчийн дүр төрх, үзэгчдийн шаардлага, нэвтрүүлгийн төрөл зүйл, дүр төрхийн ухаан, дамжуулгын ухаан

ХХ зууны тавиад онд Америкийн "Колумбия" радио нэвтрүүлгийн компанийн "Жаран минут" нэвтрүүлгийн ерөнхий найруулагч Дон Хевит (Don Hewitt) туршлагатай сурвалжлагчаар шууд нэвтрүүлэг хөтлүүлж, хамгийн анх "хөтлөгч" гэх нэрийдлийг хэрэглэв. Харин Дундад Улсад үүнээс нэлээд хожуу, 1980 оны 7-р сард Төвийн Телевиз Хороо Дундад Улсын хамгийн анхны хөтлөгчөөр Пан Шиао (庞啸)-г нэрлэн, "Ажиглалт ба сэтгэгдэл" гэх нэвтрүүлгийг хөтлүүлснээс хойш гучаад жил болж байна. Ойрын жилүүдэд Дундад Улсын хэвлэл мэдээллийн хөгжлийг даган, телевизийн нэвтрүүлгийн төрөл зүйл ба тоо хэмжээ олширч, хөтлөгчийн эгнээ ч өргөжин, үзэгчдийн тоо ч нэмэгдэж эхлэв. Үзэгчид нэвтрүүлгийг сонирхохдоо хамгийн түрүүнд хөтлөгчийн дүр төрхийг анзаардаг бөгөөд үүний дараагаар нэвтрүүлгийн бодит агуулгыг хүлээн авдаг болохоор эрдэмтдийн хөтлөгчийн талаарх судалгаа олширч, тэдний хэл яриа, хувцаслалт, хөдлөл барил, тайзыг эзэгнэх

чадвар, аливааг сэргэгээр хүлээн авч чадамж, хэв боловсрол, гоёл засаа зэргийг олон талаас ажиглан судалж байна.

Нэг. Хөтлөгчийн дүр төрхийн тухай ухагдахуун

Одоогийн байдлаар дүр төрхийн судалгаа доорх мэт хэдэн чиглэлээр хөгжиж буй. Даруй харьцуулсан утга зохиолын хүрээнд дэх дүр төрхийн ухаан, нийтийн харилцааны ухаан дахь зохион байгуулалтын дүр төрхийн судалгаа, эдийн засгийн ухаан ба удирдлагын ухаан дахь аж ахуйн нэгжийн дүр төрхийн судалгаа, олон нийтийн дамжуулгын ухааны хүрээнд дэх зуучлуурын дүр төрхийн судалгаа хувь хүний дүр төрхийн ухаан гэх мэт. Дээрх байдлаас Дундад Улсад дүр төрхийн ухаан нь ямар нэг шинжлэх ухааны хүрээнд багтан, явцуу хүрээнд судлагдаж ирснийг харж болно. Үүнийг зарим нэг эрдэмтэн бусад шинжлэх ухаанаас салган бие даасан, тусгай шинжлэх ухааны үүднээс өргөн хүрээтэйгээр судлах оролдлого хийж байгаа боловч тэр нь төдийлөн үр дүнд хүрэхгүй байна. Энд ярьж байгаа хөтлөгчийн дүр төрх нь дээр дурдсан хувь хүний дүр төрх ба зуучлуурын дүр

төрхтэй холбоотой. Судалгааны бүтээлүүдийг ажиглавал, хөтлөгчийн дүр төрхийг заасан нэгдсэн томъёолол байхгүй. Харин дамжуулгын ухаан, сэтгэл судлал, гоо зүй, нийгмийн ухааны үүднээс олон янзаар нэрлэн томъёолж буй.

Одоог болтол Хуан Юу Мин (黄幼民), Жан Жуо (张卓)-гийн «Хөтлөгчийн дүр төрхийг бүтээх» гэх номд явцуу утгын ба дэлгэрэнгүй утгын гэж хоёр зүйлийн томъёолол өгсөн нь нэлээд нарийлаг бөгөөд нэр нөлөөтэй. Хөтлөгчийн дүр төрх нь явцуу хүрээнд бол гадаад дүр төрх ба дотоод дүр төрх гэсэн хоёр хэсгээс бүрэлдэх хувь хүний дүр төрхийг заадаг. Гадаад дүр төрх гэвэл дууны өнгө, зүс царай, бие галбир, нүүрний хувирал, хөдлөл барил, хувцаслалт, нүүр будалт, үс засалт зэрэг өнгөн давхаргын байдлыг заана. Дотоод дүр төрх гэвэл боловсрол мэдлэг, ёс суртахуун, хэв намба, зан суртал зэрэг гүн давхаргын байдлыг заана¹.

Дэлгэрэнгүй утгын хөтлөгчийн дүр төрх бол хувь хүний дүр төрх, зуучлуурын дүр төрх (нэвтрүүлгийн дүр төрх), үзэгчдийн үнэлэлт зэргийг багтаадаг. Түүний амжилт олох нь гурван элементээс шалтгаална. Нэг нь хөтлөгчийн хувь хүний дүр төрх, энэ нь суурь болох элемент, дараа нь нэвтрүүлгийн дүр төрхийн тухай хувь хүний ойлголт, энэ нь зангилгын элемент, хамгийн сүүлд үзэгчдийн биеч төрөгдөл, энэ нь хөтлөгчийн дүр төрхийг үнэлэх баримжаа болдог. Хөтлөгчийн хувь хүний дүр төрх нь нэвтрүүлгийн дүр төрхтэй нийцэх тутам үзэгчдийн таашаалыг хүртэнэ. Хөтлөгчийн хувь хүний дүр төрх, нэвтрүүлгийн дүр төрх ба үзэгчдийн үнэлэлтийн хоорондох харьцаа нь хөтлөгчийн дүр төрхийг бүтээх чиглэл ба харалтыг

тогтоож, хөтлөгчийн дүр төрхийн төрөл зүйл ба байр тогтоолтыг нөлөөлнө². Тус өгүүлэлд дэлгэрэнгүй утгын хөтлөгчийн дүр төрхийг авч үзнэ.

Хоёр. Хөтлөгчийн дүр төрхийн тухай судалгааны байдал

Өрнө дахины хөтлөгчийн үйлс Америк Улсаас эхэлсэн боловч Америк ба бусад хөгжсөн улсад хөтлөгчийн мэргэжил байхгүй. Монгол Улсын их дээд сургуулиудад ч нэвтрүүлэгч хөтлөгчийн мэргэжил байхгүй бөгөөд онолын ном, сурах бичиг, өгүүлэл цөөхөн. Дундад Улсад телевизийн нэвтрүүлгийн хөгжил орой боловч олон их дээд сургууль нэвтрүүлэгч хөтлөгчийн мэргэжлийн анги нээсэн бөгөөд тус мэргэжлийн онолын ном, сурах бичиг, өгүүлэл ч хятад хэлээр хэвлэгдэн нийтлэгдэж, монгол хэл дээр нийтлүүлж хэвлүүлсэн бүтээл бас хааяа харагдах болжээ.

Дундад Улсад хөтлөгчийн дүр төрхийн талаарх судалгаа нэн хожуу эхэлж, одоо болтол Жиан Юү Шиү (蔣育秀)-гийн бичсэн «Хөтлөгчийн дүр төрх бүтээх урлаг» (Дундад Улсын Радио Телевиз Хэвлэлийн Хороо, 2003 он) ба Хуан Юу Мин (黄幼民), Жан Жуо (张卓) нарын бичсэн «Хөтлөгчийн дүр төрхийг бүтээх» (Хуа Жун, Шинжлэх Ухаан Техник Мэргэжлийн Их Сургуулийн Хэвлэлийн Хороо, 2006 он) гэх хоёр номоос өөр дорвитой бүтээл гараагүй байна. Харин эрдэм шинжилгээний өгүүлэл нэлээд нийтлэгдэн, цөөн хүн мастер цол хамгаалах ба доктор цол хамгаалах өгүүллээ энэ сэдвээр бичжээ. Өдийг хүртэл энэ чиглэлээр монгол хэлээр хэвлэгдсэн ном, нийтлэгдсэн өгүүлэл байхгүй. Улаан «Монгол хэлний нэвтрүүлэгч хөтлөгчийн урлагийн үйлсийн

шинжилгээ» (Өвөр Монголын Сурган Хүмүүжлийн Хэвлэлийн Хороо, 2011 он) гэх номын дөрөвдүгээр бүлэгтээ нэг хэсэг болгон бичив.

Гурав. Телевизийн хөтлөгчийн дүр төрх

Үй Хун (俞虹) «Нэвтрүүлгийн хөтлөгчийн нэвтэрхий онол» гэх номдоо нэвтрүүлгийн агуулгын онцлог ба хөтлөгчийн үг яриа, нүүрний хувирал, биеийн хөдөлгөөний шаардлагыг үндэслэн телевизийн хөтлөгчийг "Сонин мэдээ, шүүмжийн нэвтрүүлгийн хөтлөгч", "Утга урлаг, цэнгээнт нэвтрүүлгийн хөтлөгч", "Сурган хүмүүжил, үйлчилгээний нэвтрүүлгийн хөтлөгч", "Спортын нэвтрүүлгийн хөтлөгч", "Хүүхдийн нэвтрүүлгийн хөтлөгч"³ гэж ангилжээ. Төвийн телевиз хорооны найруулсан «Телевизийн хөтлөгчийн ажил мэргэжлийн уур чанарыг үнэлэх үзүүлэлтийн тогтолцооны судалгааны үр бүтээлийн эмхтгэл» гэх номд олон нийтийн зүгээс дээр дурдсан адил бус нэвтрүүлгийн хөтлөгчийн дүр төрхөд тавьсан шаардлагыг дурдсан нь хөтлөгчийн дүр төрхийг хувь хүний дүр төрх, нэвтрүүлгийн дүр төрх ба үзэгчдийн үнэлэлт гэх дэлгэрэнгүй утгаас нь судлахад чухал эш баримт хангаж өгөв.

1. Сонин мэдээ, шүүмжийн нэвтрүүлгийн хөтлөгчийн дүр төрх

Олон нийтийн зүгээс тавьж байгаа шаардлагаар бол "Сонин мэдээ шүүмжийн нэвтрүүлэг"-ийг дээд боловсролтой, мэдлэгийн цар хүрээ өргөнтэй, ямар ч насны хүн хөтөлж болох бөгөөд гадаад хэл мэддэг, баримжаа авиагаар ярьдаг, эрэгтэй хөтлөгч бол нэн сайн гэж үздэг. Мөн нэвтрүүлгийг хөтөлж байх үедээ төвлүүлэн, үг яриа урсам

сайхан, товч тодорхой, сэтгэхүй хурц сэргэг, дууны өнгө сонсголонтой илтгэлт оновчтой байхыг таашаадаг байна⁴. Энэ мэтээр тус төрлийн нэвтрүүлгийн хөтлөгчийн дотоод, гадаад дүр төрхийн талаарх шаардлагыг нэлээд нарийлаг дурдав.

Өвөр Монголын Монгол Одон Телевизийн "Одон мэдээ", "Өглөөний мэдээ", "Үдийн мэдээ", "Үдшийн мэдээ" зэрэг сонин мэдээний нэвтрүүлгийн хөтлөгч нар олон нийтийн зүгээс тэдэнд тавьдаг, дээр дурдсан шаардлагуудыг ерөнхийдөө хангаж байгаа хэдий ч зарим үед баримжаа авиагаар ярихгүй тохиолдол ажиглагддаг. Жишээлбэл 2009 оны 11-р сарын 5-ны өдрийн Өвөр Монголын Монгол Одон Телевизийн Сонин мэдээгээр "Дулаан гэр" гэх утгатай "хүлэмж"-ийг "гүлэмж" хэмээн ярьж гарсан ба бод, бог малын "бог" гэдэг үгийг хоёронтоо "буг" гэж ярьсан байна⁵.

Нүүрний хувирал, биеийн хөдөлгөөн төв чанга байх зарчмыг баримталж байгаа боловч "Өглөөний мэдээ" болон "Үдийн мэдээ"-ний эмэгтэй хөтлөгчийн царайд инээмсэглэл тодорч буй. "Одон мэдээ"-нээс бусад сонин мэдээний нэвтрүүлгийг ингэж хөтөлж буй нь үзэгчдэд ойр дотно сэтгэгдэл төрүүлж, улмаар хүлээн авагчдын тоог нэмэгдүүлэх ач холбогдолтой. Жишээлбэл, 2014 оны 3-р сарын 11-ний өдрийн "Үдийн мэдээ"-г хөтөлсөн Цэцэгмаа инээмсэглэл тодруулж, зөөлөн аясаар удаавтар ярьж байв. 2014 оны 3-р сарын 9-ний өдрийн "Үдийн мэдээ"-нд хөтлөгч Долгион нүүрний хувирал төвлүүлэн, биеэ өмнөш хойш ялимгүй хөдөлгөн, бага зэрэг чөлөөтэйгөөр ярьж байв.

Гоёл заслын талаар байгаллаг байхыг эрхэмлэж, эмэгтэй хөтлөгч нар уруул болон нүдэндээ хурц тод биш гүн

өнгийн будгийг сонгон хэрэглэж байгаа. Тэд үсээ богинохон загвараар засуулдаг нь үзэгчдэд төв чанга, шуурхай сэтгэгдэл төрүүлдэг юм. Урт үстэй зарим эмэгтэй хөтлөгч үсээ ардаа дээш шуудаг нь хүмүүст мөн л төв чанга, шуурхай сэтгэгдэл төрүүлдэгтэй холбоотой. Эмэгтэй хөтлөгч нар хааяа сондор, энгэрийн хатгуур зүүдгийг эс тооцвол энэ төрлийн нэвтрүүлгийн хөтлөгчид ерөнхийдөө гоёл заслын эд хэрэглэдэггүй. 2014 оны 3-р сарын 10-ны өдрийн "Өглөөний мэдээ"-ний хөтлөгч Цацраа хүзүүндээ тойрог хэлбэрийн сондор зүүж байв. Түүний царайны хэлбэр дөрвөлжин учраас тойрог хэлбэрийн сондрыг сонгосон нь тохиромжтой.

Хувцас заслын хувьд хөтлөгч нар голдуу костюм өмсдөг бөгөөд эмэгтэй хөтлөгч хааяа костюмоос өөр, ажил хэрэгч бусад хувцсыг сонгож байна. Мөн эмэгтэй хөтлөгчийн хувцасны өнгө нь эрэгтэй хөтлөгчийн зүүсэн зангиатай адилхан буюу ойролцоо өнгөтэй байхыг чухалчилж буй. 2014 оны 2-р сарын 19-ний өдрийн "Одон мэдээ"-ний хөтлөгч Алиа гүехэн улаан өнгийн костюм өмсөж, хөтлөгч Төмөрхуяг гүехэн улаан өнгийн зангиа зүүж, саарал өнгийн костюм өмсөв. Эдгээр нь сонин мэдээний нэвтрүүлгийн онцлог ба олон улсын хөтлөгчийн хувцас заслын хэв намбатай уялдан нэгдэж байна. Гэхдээ баяр дурсгалын өдөр бол монгол тэрлэг өмсдөг. 2014 оны 1-р сарын 31-ний өдөр бол цагаан сарын шинийн

нэгэн. Энэ өдрийн "Одон мэдээ"-г хөтөлсөн Өнөрцэцэг нь заам, энгэр, ханцуй, тохойн хэсгийн шар торгыг саарал эмжээрээр эмжсэн, түнтгэр мөр, урт ханцуйтай улаан тэрлэг өмсөж байв.

Соёл боловсролын талаар сонин мэдээний хөтлөгчийн олонх нь дээд боловсролтой, жишээлбэл, Өнөрцэцэг 2003 онд Өвөр Монголын Их Сургуулийн Утга зохиолын салбарыг төгсөж, 2005-2007 онд Хөх Хотын Телевиз Хороо, 2007 оноос нааш Өвөр Монголын Монгол Одон Телевизэд тус тус мэдээ нэвтрүүлж буй. Хөтлөгч Долгион Өвөр Монголын Их Сургуулийн Монгол Судлалын Дээд Сургуулийн Сонин мэдээ, хэвлэлийн ухааны салбарын нэвтрүүлэгч хөтлөгчийн мэргэжлийн ангид суралцаж төгсжээ.

Гадаадын иймэрхүү төрлийн нэвтрүүлгийн нэрт хөтлөгчийн ихэнх нь сурвалжлах, найруулах ажлын олон жилийн элбэг баян туршлагатай, мэдлэгийн хүрээ хэвцээ өргөнтэй бөгөөд дайны талбарт ч гэсэн сурвалжлах найруулах ажлаа хийдэг болохоор асуудлыг олон талаас гүнзгий ажиглахдаа гаргуун, гүнцтэй мэдээлэл дамжуулахдаа сайн байдаг. Мөн гэнэтийн санамсаргүй хэрэг үүсэх үед шаардлагатай арга хэмжээг цаг алдалгүй авах чадвартай, хурц сэргэг сэтгэхүйтэй. Эх бичгийн боловсруулалт сайн хийдэг тул маш оновчтой, товч тодорхой үгээр илтгэдэг. Иймээс дотоод дүр төрхийн хувьд үзэгчдийн

«
Гэнэтийн санамсаргүй хэрэг үүсэх үед шаардлагатай арга хэмжээг цаг алдалгүй авах чадвартай, хурц сэргэг сэтгэхүйтэй. Эх бичгийн боловсруулалт сайн хийдэг тул маш оновчтой, товч тодорхой үгээр илтгэдэг. Иймээс дотоод дүр төрхийн хувьд үзэгчдийн бишрэл хүндэтгэлийг нэн олсон байна
»

бишрэл хүндэтгэлийг нэн олсон байна. Төвийн телевиз хорооны Шүй Жүн И (水均益), Бай Янь Сун (白岩松). Жин И Дан (敬一丹) зэрэг хөтлөгч хурц сэргэг сэтгэхүй, асуудлыг гүнцтэй задлах чадвартай болохоор гадаадын нэрт хөтлөгчийнх шиг дотоод дүр төрхөөрөө үзэгчдийн сайшаал хүндэтгэлийг олов. Өвөр Монголын Монгол Одон Телевизийн хөтлөгчийн олонх нь их сургуулиа төгсмөгц шууд ажлын талбарт гардаг болохоор Дундад Улс болон гадаадын зарим нэрт хөтлөгчтэй харьцуулбал туршлага дутмаг, асуудлыг гүнцтэй ажиглах чадвар дулимаг зэрэг дотоод дүр төрхийн талаарх асуудал оршиж байдаг. Энэ нь яриангүй мэдээллийн хэрэгслийн өмчлөлийн хэлбэр, телевиз үйлсийн хөгжил, хөтлөгч сонгох баримжаа зэрэг олон хүчин зүйлээс хамаардаг.

2. Утга урлаг, цэнгээнт нэвтрүүлгийн хөтлөгчийн дүр төрх

Олон нийтийн зүгээс тавьж байгаа шаардлагаар бол "Утга урлаг, цэнгээнт нэвтрүүлэг"-ийг дээд боловсролтой, мэдлэгийн цар хүрээ өргөнтэй, хөгжимдөж тоглох авьяастай, зөв дүр төрхтэй, дууны өнгө сонсголонтой, 19-45 насны хүн хөтөлж болох бөгөөд баримжаа авиагаар оновчтой, амьдлаг илтгэдэг, эмэгтэй хөтлөгч бол нэн сайн гэж үздэг. Нэвтрүүлгийг хөтлөх үедээ чөлөөтэй, цовоо сэргэлэн, элгэмсүү, юмэрлэг, инээд бялхам бөгөөд нүүрний хувиралт олон, хэл ам хурц байхыг илүүд үздэг байна. Мөн үзэгчидтэй үзэл бодлоо халуун дотноор хуваалцахыг нэн илүү эрхэмлэдэг байна.

Дундад Улсад "Утга урлаг, цэнгээнт нэвтрүүлэг"-ийн хөгжил ХХ зууны ерээд оонос эхэлсэн ба хүмүүсийн оюун санааны амьдралын салшгүй бүрэлдэхүүн хэсэг болсон юм. Монгол Одон

Телевизийн энэ төрлийн нэвтрүүлэг саяхнаас буюу ХХI зуун гарснаас хойш л үзэгчдэд хүрч байгаа тул хөгжлийнхөө эхлэлтийн шатанд явж байгаа хэмээн ойлгож болно.

"Авьяаслаг монгол" цэнгээнт нэвтрүүлгийн хөтлөгч Идэрбаатарын дууны өнгө сонсголонтой, хөдлөл чөлөөтэй, үг яриа урсам сайхны дээр нэвтрүүлгийг нүүрэндээ инээмсэглэл тодруулан, цовоо цолгин хөтөлдөг нийм төрлийн нэвтрүүлгийг зохион түвшинд амжилттай хөтөлж байгаагийн тод илрэл хэмээн дүгнэхэд буруу хөгжимдөж тоглох чадвар ажиглагдахгүй.

Хувцаслалт, зүүсгэл гоёлын хувьд "Сонин мэдээ, шүүмжийн нэвтрүүлэг"-ийн хөтлөгчтэй харьцуулбал сонголт нэлээд чөлөөтэй бөгөөд шинэлэг хийцтэй монгол тэрлэг, чөлөөт загварын костюм, үндэсний онцлог бүхий жун шан хувцас зэргийг өмсөж, хувцасны өнгө нь гүехэн цайвар байх онцлогтой. "Авьяаслаг монгол" нэвтрүүлгийн хөтлөгч Идэрбаатар нь заам болон тохойн хэсгээрээ хээ угалзан эмжээртэй, монгол үндэсний өвөрмөц онцлогтой, гүехэн цайвар өнгийн босоо захтай хувцас буюу костюм өмсдөг. Хөх Хотын Үндэсний Дээд Сургуулийн төгсөгч, "Одод түгэх цаг" нэвтрүүлгийн хөтлөгч Алимаа гол төлөв шинэлэг загварын гэгээлэг, гүехэн өнгийн монгол тэрлэг өмсдөг боловч тухайн өдрийн уригдсан зочныхоо өмссөн хувцастай өөрийн хувцсыг зохицолдуулахыг чухалчилдаг нь анзаарагддаг.

Гоёл заслын хувьд эмэгтэй хөтлөгч нар өмсөж байгаа хувцастайгаа зохицуулан сондор, ээмэг, энгэрийн хатгуур зүүдэг. Жишээлбэл, 2014 оны 3-р сарын 21-ний өдрийн "Одод түгэх

цаг" нэвтрүүлгээр хөтлөгч Алимаа гүн хөх өнгийн тэрлэг өмсөн, хар өнгийн, унжлагагүй том ээмэг зүүсэн нь маш зохисон байлаа. Тэрээр гүн өнгийн хувцас өмсөхдөө хар бараан ээмэг зүүж, гүехэн цайвар өнгийн хувцсан дээр мөнгөлөг, гэгээлэг өнгийн ээмэг сонгодог онцлогтой.

3. Сурган хүмүүжил, үйлчилгээний нэвтрүүлгийн хөтлөгчийн дүр төрх

Олон нийтийн зүгээс тавьж байгаа шаардлагад "Сурган хүмүүжил, үйлчилгээний нэвтрүүлэг"-ийг дээд боловсролтой, мэдлэгийн цар хүрээ өргөнтэй, аль нэг мэргэжлийг гаргуун эзэмшсэн, ямар ч насны хүн хөтөлж болох бөгөөд гадаад хэл мэддэг, оновчтой үг хэллэг ашиглаж чаддаг, баримжаа авиагаар ярьдаг байх хэрэгтэй гэж дурдсан байдаг. Гадаад дүр төрхийн талаар онцгой шаардлага тавьдаггүй боловч нэвтрүүлгийг чөлөөтэй хөтөлж, үзэгчидтэй бодол санаагаа халуун дотно, эелдгээр солилцох хэрэгтэй гэж үздэг байна.

Энэхүү төрлийн нэвтрүүлэг нь үзэгчдийг сурган хүмүүжүүлж, тэдэнд олон талын мэдээллийг дамжуулдаг учир мэдлэг ухааныг түгээн дэлгэрүүлж, нийгмийг шаардлагатай мэдээллээр хангадаг онцлогтой. Сурган хүмүүжлийн нэвтрүүлэг нь үзэгчдэд ойлгоход түвэгтэй, хүндэвтэр зүйлийг энгийн байдлаар тайлбарлан хүргэхийг чухалчилдаг бол үйлчилгээний нэвтрүүлэг нь олон нийтийг амьдралын ухаанд сургаж, алхам тутамд тохиолддаг аливаа асуудлыг зөв зүйтэй шийдвэрлэхэд тус дөхөм болохыг зорьдог байна. Өвөр Монголын Монгол Одон Телевизийн сурган хүмүүжил, үйлчилгээний нэвтрүүлгийн хөтлөгч нар ерөнхийдөө "Үзэгчдэд

хэрхэн нэн сайн үйлчлэх вэ?" гэсэн зорилгыг баримталж буй нь ажиглагддаг. Үүнийг тэдний ярьж буй зүйл, ярианы аяс, нүүрний халуун дотно илрэлээс олж харж болно.

"Урсгал" дэлгэцийн хөтлөгч Отгонсод эелдэг дотно үг яриа, аяс аялга, уригдсан зочноо хүндэтгэж байгаа байдлаараа бусад хөтлөгчөөс ялгардаг. 2014 оны 4-р сарын 2-ны өдрийн "Урсгал" дэлгэцээр хөтлөгч Отгонсод "Сайн байцаана уу? Яг одоо Монгол Одон Телевизээрээ соёлын сэтгүүлч гэсэн нэвтрүүлэг "Урсгал" дэлгэцийнхээ энэ дугаараа сонирхож байгаа Та бүхэнд өнөөдрийн өлзийтэй сайхан мэндийг дэлгэцийнхээ хамт олны өмнөөс айлтгаж байна. Манай дэлгэц гараг болгоны гаргийн нэгнээс гаргийн дөрвөн болтол өдөр болгоны яг энэ цагаар «Аяны ганзага», «Цагийн анир», «Гэрэлтэй цонх» зэрэг гурван булангаар дөчин минутаар хүрдэг гэдгийг манай үзэгчид юу андах вэ? Тэгвэл энэ дугаарын «Гэрэлтэй цонх», «Цагийн анир», «Аяны ганзага»-аар ямархан агуулга бэлтгэсэн бол гэж Та бүхэн хүсэн хүлээж байгаа биз..." гэж сайн танилтайгаа уулзсан юм шиг эелдэг дотно ярьж байв. Хувцаслалтын хувьд ч тогтсон хатуу загварт баригдалгүй гэгээлэг өнгөтэй цамц, костюм, шинэ маягийн монгол тэрлэг өмссөн нь аятайхан харагдаж байв.

Олон нийтийн зүгээс энэ төрлийн нэвтрүүлгийг хөтөлдөг хүмүүст гадаад байдлын талаар онцгой шаардлага тавьдаггүй боловч хөтлөгч нар хувцаслалт, гоёл заслын эдийн зохицол, нүүр будалт, үс засалт зэрэгтээ нэлээд анхаардаг нь ажиглагддаг. Тухайлбал, 2013 оны 9-р сарын 13-ны өдрийн "Амьдралын хань" дэлгэцээр хөтлөгч Нарантуяа цагаан бор өнгө алагласан, монгол онцлогтой банзал өмсөн,

хувцасныхаа өнгөтэй зохицолдуулан бор өнгийн навчин хэлбэртэй, том унжлагатай эзмэг зүүсэн нь аятайхан харагдаж байлаа.

Дээр дурдсан хөтлөгч Отгонсод Өвөр Монголын Их Сургуулийн Сонин мэдээ, хэвлэлийн ухааны салбарыг нэвтрүүлэгч хөтлөгчийн мэргэжлээр дүүргэмэгц Өвөр Монголын Монгол Одон Телевизэд хөтлөгчөөр ажиллав. Тэрбээр 2007 оноос нааш "Соёл-Эрдэнэ", "Мөр", "Өглөөний мэдээ", "Кино ордон" зэрэг дэлгэцийн хөтлөгч, найруулагчаар ажиллаж ирсэн болохоор мэдлэгийн цар хүрээ нэлээд өргөжиж, арвин туршлага хуримтлуулжээ.

4. Спортын нэвтрүүлгийн хөтлөгчийн дүр төрх

Олон нийтийн зүгээс тавьж байгаа шаардлагаар бол "Спортын нэвтрүүлэг"-ийг Техник Мэргэжлийн Сургуулийн түвшнээс дээш боловсролтой, мэдлэгийн хүрээ хэвцээ өргөнтэй, аль нэг мэргэжилд гаргуун, дууны өнгө сонсголонтой, хурц сэргэг сэтгэхүйтэй, 19-45 насны эрэгтэй хүн хөтөлж болох бөгөөд гадаад хэл мэддэг, баримжаа авиагаар ярьдаг, оновчтой үг хэллэг ашиглаж чаддаг байх хэрэгтэй гэж дурдсан байдаг. Мөн нэвтрүүлгийн хөтлөхдөө чөлөөтэй, юмэрлэг байх нь чухал гэж үзэж⁸ буй.

"Спортын нэвтрүүлэг"-ийн хөтлөгч нь сурвалжлах, тайлбарлах, мэдээлэх, шүүмжлэх ажлуудыг хариуцан хийдэг болохоор бусад төрлийн нэвтрүүлгийн хөтлөгчөөс олон талаар ялгаатай бөгөөд спортын өргөн цар хүрээний мэдлэгтэй, сурвалжлах өндөр түвшний чадвартай, найруулан бичих дадал туршлагатай байх шаардлагатай байдаг. Өвөр Монголын Монгол Одон Телевизийн "Тамир урлагийн ертөнц"

нэвтрүүлгийг дөч эргэм насны Хосбаяр хэмээх хөтлөгч бэлтгэн хүргэдэг билээ. Тэрбээр 2014 оны 3-р сарын 16-ны өдрөөс мөн оны 3-р сарын 30-ны хооронд Япон Улсад болсон бөхийн барилдааныг халуун цэг дээрээс нь сурвалжлан, бөх судлаач доктор Б. Болдтой хамтран тайлбарлаж, гурван удаагийн сонирхолтой, цуврал нэвтрүүлгийг үзэгчдэд бэлтгэн хүргэсэн юм. Үзэгчид хөтлөгчийн тайлбар, мэдээлэлд бүх анхаарлаа хандуулдаг болохоор тэдний гадаад дүр төрхийг төдий л анзаардаггүй. Дээр дурдсан гурван удаагийн цуврал нэвтрүүлгийн үеэр хөтлөгч Хосбаяр саарал костюм, цагаан цамц өмсөн, зангиа зүүсэн байв.

5. Хүүхдийн нэвтрүүлгийн хөтлөгчийн дүр төрх

Олон нийтийн зүгээс тавьж байгаа шаардлагаар бол "Хүүхдийн нэвтрүүлэг"-ийг Техник Мэргэжлийн Сургуулийн түвшнээс дээш боловсролтой, мэдлэгийн цар хүрээ өргөн, аль нэг мэргэжилд гаргуун, тоглож наадах урдүйтэй, хөгжмийн авьяастай, дууны өнгө сонсголонтой, сэргэлэн цовоо, хэллэг хурц тод, хүүхдийрхүү ааш аальтай, 19-30 насны эмэгтэй хүн хөтөлж болох бөгөөд баримжаа авиагаар ярьдаг, оновчтой үг хэллэг ашиглаж чаддаг байх хэрэгтэй гэж дурдсан байдаг. Мөн нэвтрүүлгийг хөтлөхдөө чөлөөтэй, зөлдэг элгэмсүү, цовоолог, жавхаатайгаар инээмсэглэл гэрэлтүүлэн хөтлөх ёстой⁹ гэж үздэг байна.

Хүүхдийн нэвтрүүлгийн хөтлөгч нарыг асуудлыг гүнзгий боловсруулан задлахыг шаардахгүй боловч хүүхэдтэй үзэл бодлоо хялбархнаар солилцох чадвартай байхыг шаардана. Өвөр Монголын Монгол Одон Телевизийн "Хүүхдийн нэвтрүүлэг"-ийг хорь орчим насны залуус хөтөлдөг бөгөөд тэд олонхдоо чөлөөт загварын хувцас сонгон өмсдөг. Нэвтрүүлгийг хүүхдийн цовоо цолгин, шингэн дуугаар хөөр баяртай хөтөлж, аливаа мэдлэг мэдээллийг үзэгч хүүхдүүдэд хүргэхдээ чөлөөтэй, хөгжил наргиантай орчинд яг тэдний ах эгч шиг тайлбарлаж өгдөг юм. 2014 оны 4-р сарын 14-ний өдрийн "Нахиа" дэлгэцээр хөтлөгч Цэцэнтүяа ягаан өнгийн банзал өмсөн, толгойдоо мөн тийм өнгийн цэцэг хатгасан нь маш хөөрхөн харагдаж байв. Түүнчлэн толгой, биеэ нааш цааш хөдөлгөн, нүдээ хөөрхөн гэгч цавчилж, хүүхдийн хөөрхөн дуугаар баяр хөөртэй хөтөлж байлаа. Цэцэнтүяа 2007 онд Хөх Хотын Үндэстний Дээд Сургуулийн Сонин Мэдээний Салбарын Нэвтрүүлэгч хөтлөгчийн ангийг дүүргэн, Өвөр Монголын Монгол Одон Телевизэд орсноос хойш "Нахиа" дэлгэцийн хөтлөгчөөр одоо болтол ажиллаж буй.

Дээр дурдсан үзэлтүүд нь хөтлөгчийн дүр төрх бол нэвтрүүлгийн онцлог, хэв шинжтэй заавал авчлалдах ёстой бөгөөд тийм байж чадаж гэмзэнэ л үзэгчдийн таашаал хүндлэлийг олдгийг батлан харуулж байна. Олонх үзэгч боловсролын түвшин өндөр, илтгэх чадвар сайн хөтлөгчийг илүү ойшоодог нийтлэг онцлогтой. Гэвч адил бус төрлийн нэвтрүүлгийн үзэгчдийн нас хүйс, соёлын хэр түвшин, гоо сайхны үзэл ухамсар харилцан адилгүй учраас хөтлөгчид тавих шаардлага бас адил бус байдаг. Иймээс адил бус төрлийн нэвтрүүлгийн хөтлөгч нар олон нийтийн зүгээс тэдэнд тавьж байгаа шаардлагад нийцүүлэн дүр төрхөө тасралтгүй төгөлдөржүүлэх ёстой.

Телевизийн нэвтрүүлгийн хөтлөгчийн дүр төрх бол судалгааны асар

том сэдэв боловч Дундад Улсад одоогийн байдлаар энэ чиглэлийн судалгаа дөнгөж эхлэлтийн шатандаа явж байна. Учир нь энэхүү судлагдахууныг бие даасан байдлаар бус аль нэг суурь шинжлэх ухааны хүрээнд дамжуулгын ухаан, үзэгчдийн үнэлэмж, хувь хүний имиж бүрдүүлэлт зэрэг талаас нь нэвтрүүлгийн төрөл зүйл, онцлогтой уялдуулан судалж байна. Гэхдээ бүх судалгаа эхлэлтийн шатандаа явж байгааг дурдах хэрэгтэй. Тус өгүүлэлд Өвөр Монголын Монгол Одон Телевизийн хөтлөгчийн дүр төрхийг нэвтрүүлгийнх нь төрөл зүйл онцлогтой уялдуулан, гол төлөв гадаад дүр төрхийн талаас ажиглав. Өвөр Монголын Монгол Одон Телевизийн хөтлөгч нарын илтгэх чадвар, хувцаслалт, гоёл засал, хөдлөл барил зэрэг гадаад дүр төрх нь олон нийтийн зүгээс тавьдаг шаардлагад ерөнхийдөө нийцэж буй. Хөтлөгчийн дотоод дүр төрхөд эрдэм мэдлэг, хэв боловсрол, ёс суртахуун, сэтгэц сэтгэхүй зэрэг олон элемент багтдаг болохоор дотоод дүр төрх нь урт хугацааны туршлага, идэвх чармайлтын дүнд тасралтгүйгээр хуримтлагдан төгөлдөрждөг. Өвөр Монголын Монгол Одон Телевизийн байгуулагдсан цаг орой, бүр XXI зуунаас эхэлж хөгжсөнөөс хөтлөгчийн эрдэм мэдлэг, ажлын туршлага, үйлдлэг, сэтгэц, сэтгэхүй зэрэг дотоод дүр төрхийн талаарх хуримтлал цөөхөн байна. Энэ тухай хөтлөгч Г. Чинбаатар асны номд "Дэлхийн хөтлөгчтэй нэвтрүүлгийн хөгжилтөөс төв радио, төв телевиз ч алхам хоцорч байгаа болохоор цөөн тоот үндэстний хэлээр яригч мужийн дэсийн радио телевизийн хөтлөгчтэй нэвтрүүлэг бэрх хатуу холын замыг туулах анхны алхмаа алхаж байгаа төдий юм"¹⁰ гэж хэлсэн байдаг. Иймээс Өвөр Монголын

Монгол Одон Телевизийн хөтлөгч нар дотоод дүр төрхөө төгөлдөржүүлэх тал дээр анхаарлаа илүүтэй хандуулан, идэвхийлэн чармайж, Дундад Улсдаа цаашлаад дэлхийн түвшинд хүрэхийг хичээвэл зохино.

Ишлэл

¹ Хуан Юу Мин (黄幼民), Жан Жуо (张卓). Хөтлөгчийн дүр төрхийг бүтээх. Хуа Жун Шинжлэх Ухаан Техник Мэргэжлийн Их Сургуулийн Хэвлэлийн Хороо, 2006, х. 9.

² Мөн тэнд, х. 15-16.

³ Үй Хун (俞虹). Программын хөтлөгчийн нэвтэрхий онол. Дундад Улсын Радио Телевизийн Хэвлэлийн Хороо. 2004, х. 86-90.

⁴ Ху Юн Фан (胡运芳), Ван Ши Жиэн (王晞建). Телевизийн нэвтрүүлгийн хөтлөгчийн ажил мэргэжлийн уур чанарыг үнэлэх үзүүлэлтийн тогтолцооны судалгааны үр бүтээлийн эмхтгэл. Дундад Улсын Радио Телевиз Хэвлэлийн Хороо. 1999, х. 7.

⁵ Мөлсөн. Монгол зуучлуурын хэлний дүрэмжлийн шинжилгээ. Өвөр Монголын Хэвлэлийн Бүлэгэл, Өвөр Монголын Сурган Хүмүүжлийн Хэвлэлийн Хороо, 2011 он. х. 151.

⁶ Ху Юн Фан (胡运芳), Ван Ши Жиэн (王晞建). Телевизийн нэвтрүүлгийн хөтлөгчийн ажил мэргэжлийн уур чанарыг үнэлэх үзүүлэлтийн тогтолцооны судалгааны үр бүтээлийн эмхтгэл. Дундад Улсын Радио Телевиз Хэвлэлийн Хороо. 1999, х. 7-8.

⁷ Мөн тэнд, х. 8.

⁸ Мөн тэнд, х. 8.

⁹ Мөн тэнд, х. 8.

¹⁰ Чинбаатар Г. Хөтлөгчийн хань. Өвөр Монголын Хэвлэлийн Бүлэглэл, Өвөр Монголын Ардын Хэвлэлийн Хороо. 2011 он. 55 дугаар тал.

Ашигласан бүтээлийн жагсаалт

1. Мөлсөн. Монгол зуучлуурын хэлний дүрэмжлийн шинжилгээ. Өвөр Монголын Хэвлэлийн Бүлэгэл, Өвөр Монголын Сурган Хүмүүжлийн Хэвлэлийн Хороо. 2011.

2. Үй Хун (俞虹). Программын хөтлөгчийн нэвтэрхий онол. Дундад Улсын Радио Телевизийн Хэвлэлийн Хороо. 2004.

3. Хуан Юу Мин (黄幼民), Жан Жуо (张卓). Хөтлөгчийн дүр төрхийг бүтээх. Хуа Жун Шинжлэх Ухаан Техник Мэргэжлийн Их Сургуулийн Хэвлэлийн Хороо, 2006.

4. Ху Юн Фан (胡运芳), Ван Ши Жиэн (王晞建). Телевизийн нэвтрүүлгийн хөтлөгчийн ажил мэргэжлийн уур чанарыг үнэлэх үзүүлэлтийн тогтолцооны судалгааны үр бүтээлийн эмхтгэл. Дундад Улсын Радио Телевиз Хэвлэлийн Хороо. 1999.

5. Чинбаатар Г. Хөтлөгчийн хань. Өвөр Монголын Хэвлэлийн Бүлэглэл, Өвөр Монголын Ардын Хэвлэлийн Хороо. 2011 он. 55 дугаар тал.

Резюме

Автор в данной статье рассматривает аспекты мастерства телеведущего на примерах ведущих телевидения "Одон" ("Звезда") Внутренней Монголии. Считается, что первый телеведущий КНР на экранах страны появился лишь в июле 1980 года. Во Внутренней же Монголии телеведущий появился значительно позже. В настоящее время во Внутренней Монголии отношение к телеведущим особое. Автор рассматривает специфику телеведущего на примерах ведущих: 1. Информационных и аналитических программ, 2. Развлекательных программ, 3. Педагогических и утилитарных программ, 4. Спортивных программ, 5. Детских программ.